



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 12 дугаар  
сарын 21-ний өдөр

Дугаар 470

Улаанбаатар  
хот


Журам шинэчлэн батлах тухай

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9.3.7-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Энэ тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавьж дэмжлэг үзүүлж ажиллахыг Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатарт тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2021 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн 119 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Эдийн засаг, хөгжлийн сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Ч.ХҮРЭЛБААТАР

Засгийн газрын 2022 оны 470 дугаар  
тогтоолын хавсралт

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧИГ  
БОЛОВСРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 4.1.4-4.1.14-т заасан Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг боловсруулахад энэ журмыг баримтална.

1.2. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг болон Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах заавар, аргачлал, загварыг үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн онцлог, хуулиар тогтоосон тавигдах шаардлагад нийцүүлэн баримт бичиг тус бүрээр батална.

1.3. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг боловсруулахдаа хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлах бөгөөд Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн үргийн хүрээнд хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй уялдуулна.

Хоёр. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төсөл боловсруулах удирдлага, зохион байгуулалт

2.1. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан заавар, аргачлал, загварын дагуу хуулийн 6, 11 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаж, 10 дугаар зүйлд заасан үе шат, 12-18 дугаар зүйлд заасан цаглаврын дагуу боловсруулна.

2.2. Хуулийн 4.1.4-4.1.6, 4.1.8, 4.1.9, 4.1.12, 4.1.13-т заасан баримт бичгийн төслийг үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.

2.3. Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хуулийн 4.1.7, 4.1.10, 4.1.14-т заасан баримт бичгийн төслийг хуулийн 6.7, 6.8, 6.10-т заасан шаардлага болон үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан заавар, аргачлал, загварыг баримтлан боловсруулсан эсэхийг нягталж, санал, дүгнэлтээ аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ.

2.4. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь аймаг, нийслэлийн Засаг даргын өргөн мэдүүлсэн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг батлахдаа хуульд заасан шаардлагыг хангасан эсэх,

үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал, дүгнэлтийг харгалзан үзнэ.

2.5.Хуульд заасан эрх бүхий байгууллага хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулахад шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг урьдчилан төлөвлөсөн байна.

---ооо---

